



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“Нөхөн сонгуулийг зохион байгуулахтай холбогдуулан
улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт,
зарцуулалт, тайлагнал”

АУДИТЫН КОД: СБА-2022/20/-11 НА-СТА

Баруун-Урт 2022 он

Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа
Утас: 70518396, Цахим хаяг: Narantuyam@audit.gov.mn

Аудитын менежер Г.Даваа
Утас: 70512123, Цахим хаяг: Davaag@audit.gov.mn

Ахлах аудитор С.Ариунбаяр
Утас: 70512123, Цахим хаяг: Ariunbayars@audit.gov.mn

Аудитор: Б.Ариунзул
Утас: 70512123, Цахим хаяг: Ariunzulb@audit.gov.mn

Аудитор: А.Мөнхцэцэг
Утас: 70512123, Цахим хаяг: Munkhtsetsega@audit.gov.mn



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2022 оны 07 сарын 20 өдөр

Дугаар А/21

Баруун-Урт сум

Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

"Орон нутгийн Хурлын нөхөн болон дахин сонгууль зохион байгуулах зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд хийх аудит" сэдэвт аудитын тайланг баталгаажуулсугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *М.Нарантуяа* М.НАРАНТУЯА



Агуулга	
Товчилсон үгийн тайлбар	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	2
БҮЛЭГ 1. СЕХ-оос нөхөн сонгууль зохион байгуулахад шаардлагатай төсвийг хууль журмын дагуу хуваарилсан байна.	3
1.1. СЕХ-оос нөхөн сонгууль зохион байгуулахтай холбоотой 20.5 сая төгрөг олгожээ	3
1.2. Сонгуулийн хороодод зардлын төсвийг СЕХ-оос өгсөн зааварчилгааны дагуу хуваарилжээ	3
БҮЛЭГ 2. Орон нутгийн сонгууль зохион байгуулахтай холбогдсон санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулж, батлагдсан маягтын дагуу тайлагнасан байна.	3
2.1. Аймгийн сонгуулийн хороо хуваарилагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулжээ	3
2.2. Зардлын гүйцэтгэлийг батлагдсан маягтын дагуу үнэн зөв тайлагнасан байна	4
ДҮГНЭЛТ:	4

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
УБХ	Улсын бүртгэлийн хэлтэс
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 6.6-д заасан бүрэн эрхийн хүрээнд "Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын Хурлын төлөөлөгчийн нөхөн сонгуулийг зохион байгуулахтай холбогдуулан улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалт, тайлагнал"-д аудит хийв.

Аудитын зорилт

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын Хурлын төлөөлөгчийн нөхөн сонгуулийг зохион байгуулахтай холбогдуулан улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалт, тайлагналд дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан аймгийн Сонгуулийн хороо, холбогдох байгууллагад танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан уу;
- Нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг арвилан хэмнэлттэй зарцуулсан уу.

Аудитын хамарсан хүрээ

Аудитад аймаг, сумын сонгуулийн хороод, Улсын бүртгэлийн хэлтсийг хамрууллаа.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 3000-3100, Монгол Улсын төрийн аудитын стандарт-Гүйцэтгэлийн аудит MNS 6817-7:2020, Гүйцэтгэлийн болон Санхүүгийн аудитын арга зүйг ашиглан улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын талаар холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан, судалгаа, баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийн аудитын судалгаа, хөтөлбөр, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт зөвлөмж боловсрууллаа.

Аудитын бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор М.Нарантуяа удирдаж, аудитын менежер Г.Даваа чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор С.Ариунбаяр, аудитор Б.Ариунзул, А.Мөнхцэцэг нар гүйцэтгэв.

БҮЛЭГ 1. СЕХ-оос нөхөн сонгууль зохион байгуулахад шаардлагатай төсвийг хууль журмын дагуу хуваарилсан байна.

1.1. СЕХ-оос нөхөн сонгууль зохион байгуулахтай холбоотой 20.5 сая төгрөг олгожээ

1.1.1 Нөхөн сонгууль зохион байгуулахтай холбоотойгоор Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1¹, Сонгуулийн ерөнхий хорооны 2021 оны А/17² дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу аймгийн сонгуулийн хороо болон хэсгийн хорооны тоо, түүнд ажиллах албан хаагчийн тоо зэрэг үзүүлэлтэд үндэслэн санхүүжилтийг олгосон байна. СЕХ-оос аймгийн сонгуулийн хороонд 3 удаагийн санхүүжилтээр 20.5 сая төгрөгийг хуваарилсан байна.

1.1.2 Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2³-т заасны дагуу УБЕГ-аас аймгийн УБХ-т 3.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Мөн аймгийн Цагдаагийн газарт 0.2 сая төгрөгийг ЦЕГ-аас хуваарилсныг захиран зарцуулж санхүүгийн баримтыг дээд шатны байгууллагад хүргүүлсэн байна.

1.2. Сонгуулийн хороодод зардлын төсвийг СЕХ-оос өгсөн зааварчилгааны дагуу хуваарилжээ

1.2.1 Сонгуулийн ерөнхий хорооны ажлын албаны 2022 оны 3/51, 3/82 дугаар албан бичгээр аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны төсвийг зарцуулах зааварчилгааг хүргүүлсэн байна. Мөн Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2022 оны А/17 дугаар захирамжаар нөхөн сонгуулийн аймаг, сумын хэсгийн хорооны гишүүн, нягтлан бодогч, даамал, бусад ажилчдын мөнгөн урамшууллыг баталсан байна.

1.2.2 Аймгийн сонгуулийн хороо СЕХ-ны ажлын албанаас ирүүлсэн зааварчилгааны дагуу аймаг, сумын сонгуулийн хорооны зардлыг үнэн бодиттой тооцож улсын төсвөөс хуваарилсан хөрөнгөнөөс 8.9 сая төгрөгийн Сүхбаатар сумын сонгуулийн хэсгийн хороонд хуваарилжээ.

БҮЛЭГ 2. Орон нутгийн сонгууль зохион байгуулахтай холбогдсон санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулж, батлагдсан маягтын дагуу тайлагнасан байна.

2.1. Аймгийн сонгуулийн хороо хуваарилагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулжээ.

2.1.1. Аймгийн сонгуулийн хорооноос нөхөн сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотойгоор сумын сонгуулийн хороонд 20.5 сая төгрөгийг зарцуулахаар хуваарилснаас, гүйцэтгэлээр 20.5 сая төгрөгийн зарцуулсан байна.

¹ Орон нутгийн Хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон доор дурдсан зардлыг Сонгуулийн ерөнхий хорооны төсөвт тусгаж, улсын төсвөөс санхүүжүүлнэ:

² Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих, журам

³ Орон нутгийн Хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон доор дурдсан зардлыг улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын тухайн жилийн төсөвт тусгаж, улсын төсвөөс санхүүжүүлнэ:

2.1.2 Гүйцэтгэлээр гарсан нийт зардлын 48.3 хувь буюу 9.9 сая төгрөгийг сонгуулийн хороо болон, хэсгийн хороодод ажилласан албан хаагчдын урамшуулал, хоолны зардалд, 35.1 хувь буюу 7.2 сая төгрөгийг томилолтын зардалд зарцуулсан бол 16.5 хувь буюу 3.4 сая төгрөгийг байр тохижуулах, бичиг хэрэг, шуудан холбоо, маягт хэвлүүлэх зардалд тус тус зарцуулжээ.

2.1.3 УБЕГ-ын даргын 2022 оны А/368 дугаар тушаалаар Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст 3.9 сая төгрөгийн төсөв хуваарилжээ. Үүнээс улсын бүртгэлийн байгууллагын ажилтан, итгэмжлэгдсэн ажилтны мөнгө урамшуулалд 1.4 сая, сонгогчдын нэрсийн жагсаалт хэвлэхэд шаардагдах бичиг хэргийн материалын зардалд 0.6 сая, техник хэрэгслийг тээвэрлэх болон сургалтын зардалд 1.9 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

2.2. Зардлын гүйцэтгэлийг батлагдсан маягтын дагуу үнэн зөв тайлагнасан байна.

2.2.1 Аймгийн сонгуулийн хороо сонгууль зохион байгуулахтай холбогдон гарсан зардлын гүйцэтгэлийг Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар батлагдсан "Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам"-ын 2, 3 дугаар хавсралтаар батлагдсан маягтын дагуу тайлагнасан байна.

Дүгнэлт:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

- СЕХ-оос нөхөн сонгууль зохион байгуулахад шаардлагатай төсвийг хууль журмын дагуу хуваарилсан байна.
- Орон нутгийн сонгууль зохион байгуулахтай холбогдсон санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулж, батлагдсан маягтын дагуу тайлагнасан байна.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:



СҮХБААТАР АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРОО

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас, факс: 70510615

2022.07.20 № 03

танай _____-ны № _____-т

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Танай газраас ирүүлсэн "Нөхөн сонгуулийг зохион байгуулахтай холбогдуулан улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалт, тайлагнал" сэдэвт аудитын тайлантай танилцлаа.

Тус тайланд саналгүй болно.



ДАРГА *Ц.Алтанцэцэг* Ц.АЛТАНЦЭЦЭГ

ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР

Б.Ариунбаяр
Б.Ариунзул
А.Мөнхцэцэг

Б.АРИУНБАЯР
Б.АРИУНЗУЛ
А.МӨНХЦЭЦЭГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
М.НАРАНТУЯА
АУДИТЫН МЕНЕЖЕР
Г.ДАВАА

М.Нарантуяа
Г.Даваа

